



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 349

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 53,022,893.00 (тавин гурван сая хорин хоёр мянга найман зуун ерэн гурван) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож “Мэдээлэл технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал М.Баттулга, “Мэдээлэл технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Э.Цогтгэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



З.МЭНДСАЙХАН

Д.НАРАНГЭРЭЛ

300648

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн  
349 дугаар тогтоолын хавсралт

"Үндэсний дата төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, "мэдээлэл технологийн үндэсний парк" төрийн өмчит үйлдвэрийн газраас балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жил)
1	Температур чийгшил тохируулах төхөөрөмж (20RT)	1/1/2010	Ш	1	53,022,893.00	5,302,289.30	1
<b>Нийт дүн</b>					<b>53,022,893.00</b>	<b>5,302,289.30</b>	<b>1</b>
					(тавин гурван сая хорин хоёр мянга найман зуун ерэн гурван)	(таван сая гурван зуун хоёр мянга хоёр зуун наян есөн төгрөг гучин мөнгө)	